

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын  
20 . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрийн  
. . . . . тоот тушаалын хавсралт

Батлав. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал . . . . . /Х.Баатар/

“ . . . . . ”  
компанийн захирал . . . . .  
/ . . . . . /

## ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖИЙН АГУУЛАХЫН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ГЭРЭЭ

№ .....

20 . . . оны . . . -р сарын . . . -ний өдөр

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү гэрээг “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”, “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”, “Агуулахын итгэмжлэлийн журам” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд нэг талаас “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (цаашид “Бирж” гэх)-ийг төлөөлж Төлбөр тооцоо, ложистикийн хэлтсийн захирал Ц. Дуламсүрэн, нөгөө талаас “\_\_\_\_\_” ХХК (цаашид “Итгэмжлэгдсэн агуулах” гэх)-ийг төлөөлж \_\_\_\_\_ албан тушаалтай, \_\_\_\_\_ регистрийн дугаартай, \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нар харилцан тохиролцож байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээ (цаашид “Гэрээ” гэх) нь Бирж болон Итгэмжлэгдсэн агуулахын хооронд үүсэх харилцааг зохицуулах зорилготой, тэдгээрийн эрх, үүрэг, эрх зүйн чадамжийг тогтоосон, агуулахыг Гэрээний хавсралт 3-т заасан бараа, түүхий эдийн “Биржийн итгэмжлэгдсэн агуулах” гэдгийг батлах баримт бичиг мөн.
- 1.3. Гэрээг \_\_\_\_ жилийн хугацаатайгаар байгуулна. Гэрээний сунгалтын хугацааг Биржийн Гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр тогтооно.
- 1.4. Гэрээний хавсралтууд нь тус гэрээний салшгүй хэсэг мөн.

### ХОЁР. БИРЖИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1. Бирж дараах эрхтэй. Үүнд:
  - 2.1.1. Итгэмжлэгдсэн агуулахын үйл ажиллагаа, баримт бичгийн хөтлөлт, Агуулахын бүртгэлийн програмын ашиглалт болон энэхүү гэрээний нөхцлийг хангасан байдлыг хууль, журамд заасан эрхийн хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт явуулж шалгах;
  - 2.1.2. Итгэмжлэгдсэн агуулахаас хуулиар нууцлаагүй баримт бичиг, мэдээллийг шаардан гаргуулах, шалгах;
  - 2.1.3. Агуулах, ажлын байран дахь аливаа нөхцөл байдлыг сайжруулахыг шаардах, даалгавар өгөх;
  - 2.1.4. Итгэмжлэгдсэн агуулахаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг шаардах;
  - 2.1.5. Биржийн цахим системд шаардлагатай өөрчлөлт, шинэчлэлт явуулах;
  - 2.1.6. Итгэмжлэгдсэн агуулахад хариуцлага хүлээлгэх.
- 2.2. Бирж дараах үүрэгтэй. Үүнд:

- 2.2.1. Итгэмжлэгдсэн агуулахын компьютерт Биржийн Агуулахын бүртгэлийн (бараа бүртгэлийг хөтлөх) програ
- 2.2.2. мыг суулгаж, агуулахын ажилтанд зааварчилгаа өгч, хүлээлгэн өгөх (акт үйлдэх);
- 2.2.3. Агуулахын бүртгэлийн програмыг дахин суулгуулах хүсэлтийг үндэслэн програмыг дахин суулгах;
- 2.2.4. Үйл ажиллагааны нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хангах;
- 2.2.5. Итгэмжлэгдсэн агуулахын холбогдон ажилладаг цахим систем, үйл ажиллагааны горимд аливаа өөрчлөлт, шинэчлэлт хийх тохиолдолд урьдчилан мэдэгдэж, хэвийн үйл ажиллагааг хангах;
- 2.2.6. Биржийн үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын аливаа шийдвэр, холбогдох мэдээллийг Биржийн албан ёсны эх сурвалж, эсвэл мэдээлэл солилцох сувгаар дамжуулан Итгэмжлэгдсэн агуулахад мэдэгдэх.

### **ГУРАВ. ИТГЭМЖЛЭГДСЭН АГУУЛАХЫН ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Итгэмжлэгдсэн агуулах нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам”-д зааснаас гадна дараах эрхтэй. Үүнд:
  - 3.1.1. Энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг Биржээс шаардах;
  - 3.1.2. Итгэмжлэгдсэн агуулахын ашиглаж буй програмын хөгжүүлэлт, Биржийн вэб-д байршуулж буй мэдээлэл, Бирж болон Төлбөр тооцоо, ложистикийн хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, сургалтын талаар хүсэлт гаргах;
  - 3.1.3. Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэс болон итгэмжлэгдсэн агуулахын ашиглаж буй баримт бичигт зөвлөгөө, тайлбар хүсэх, өөрчлөлт оруулах хүсэлт гаргах;
  - 3.1.4. Биржийн итгэмжлэлээс татгалзах хүсэлт гаргах;
  - 3.1.5. Эдгээр хүсэлт, шаардлагыг Биржид гаргахдаа албан бичгээр хандана.
- 3.2. Итгэмжлэгдсэн агуулах нь “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон “Агуулахын итгэмжлэлийн журам”-д зааснаас гадна дараах үүрэгтэй. Үүнд:
  - 3.2.1. Итгэмжлэл авсан барааны төрөлд хамаарах Монгол улсын холбогдох стандарт болон итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах;
  - 3.2.2. Биржийн барааны тодорхойлолтыг мөрдөж, барааны чанар, хэмжээг үнэн зөв тодорхойлж ажиллах;
  - 3.2.3. Агуулахын бүртгэлийн програмыг алдаагүй ашиглах, харилцагчийн барааны бүртгэлийг үнэн зөв хөтлөх;
  - 3.2.4. Арилжаанд орох биржийн барааг програмд арилжаа эхлэхийн өмнөх ажлын өдрийн 12 цагаас өмнө бүртгэсэн байх;
  - 3.2.5. Өөрийн хүсэлтээр програм суулгуулсан, сургалтанд хамрагдсан болон бусад шалтгаанаар Биржид төлөх төлбөр үүсвэл тухай бүрт шуурхай барагдуулах;
  - 3.2.6. Ажил үүргээ гүйцэтгэж яваа Биржийн ажилтан болон харилцагчдад шуурхай үйлчилгээ үзүүлэх, үнэн зөв мэдээлэл өгөх;
  - 3.2.7. Шалгалтаар яваа Биржийн ажилтанд зураг авалт хийх, агуулахын нөөцийн мэдээллийн хуудас баталгаажуулах боломжоор хангах;
  - 3.2.8. Үйл ажиллагааны явц дахь баримт бүрийг эмх цэгцтэй хадгалах, тэдгээрийг Биржийн ажилтны шаардлагаар шалгуулах;
  - 3.2.9. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын явцад илэрсэн зөрчлийн тухай шалгалтын бүрэлдэхүүний шаардлагыг шуурхай гүйцэтгэх;
  - 3.2.10. Биржээс итгэмжлэл түдгэлзүүлсэн болон бусад аливаа тохиолдолд харилцагчид хохирол учруулах үйлдэл гаргахгүй байх.

- 3.2.11. Хадгалж буй бараанд болон хадгалалтын нөхцөлд аливаа өөрчлөлт орсон даруйд Биржийн Төлбөр тооцоо, ложистикийн хэлтэст мэдэгдэх;
- 3.2.12. Стандартчилал, хэмжил зүйн газрын гэрчилгээ бүхий баталгаат жинг ашиглах;
- 3.2.13. Харилцагчдад ажиллах нөхцөл бололцоогоо танилцуулах, сурталчлах, санал хүргүүлэх;
- 3.2.14. Барааны орлого, зарлагын анхан шатны баримт бичгийг харилцагчдад үйлчилгээ үзүүлсэн тухай бүрт өгөх;
- 3.2.15. Энэхүү гэрээний Хавсралт 2 буюу “Харилцагчтай байгуулан мөрдөх гэрээнд зайлшгүй тусгах жагсаалт”-ыг харилцагчтай хийх гэрээнд тусгана.

### **ДӨРӨВ. ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

- 4.1. Энэхүү гэрээ болон холбогдох хууль, бусад эрх зүйн баримт бичигт заасан үүргийг зохих ёсоор биелүүлээгүй нь илэрсэн, итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд зөрчлийн шинж байдал, Бирж болон харилцагчид учруулсан хохирлын хэмжээг харгалзаж, Биржээс Итгэмжлэгдсэн агуулахад дараах хариуцлагын төрлүүдээс аль тохирохыг хүлээлгэнэ. Үүнд:
  - 4.1.1. Сануулга өгөх;
  - 4.1.2. Итгэмжлэлийг түдгэлзүүлэх;
  - 4.1.3. Итгэмжлэлийн гэрээг цуцлах.
- 4.2. Бирж Итгэмжлэгдсэн агуулахад хариуцлага хүлээлгэхдээ “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон “Агуулахын итгэмжлэлийн журам”-ыг баримтална.

### **Тав. БУСАД**

- 5.1. Энэхүү гэрээг байгуулсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Итгэмжлэгдсэн агуулах Биржийн Захиргаа дотоод аудитын хэлтэст “Агуулахын итгэмжлэлийн төлбөр”-т . . . . . төгрөгийг төлнө. Агуулахын итгэмжлэлийн төлбөр төлөхгүй байх нь итгэмжлэлийг түдгэлзүүлэх үндэслэл болно.
- 5.2. Гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах ба гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 5.3. Гэрээний хугацаанд аль нэг тал Гэрээг цуцлах, нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаагүй тохиолдолд Гэрээг Биржийн гүйцэтгэх удирдлагын шийдвэрээр сунгана.
- 5.4. Гэрээний нөхцлүүд болон Биржийн аливаа журам, шийдвэрийг мэдээгүй, эсвэл ойлгоогүй нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 5.5. Гэрээнд заагдсан болон заагдаагүй нөхцөл байдлаас үүдсэн аливаа маргааныг талууд хамтдаа хэлэлцэн тохиролцож шийдвэрлэх бөгөөд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд холбогдох хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

Хөдөө аж ахуйн биржийн	“ . . . . . ”
Төлбөр тооцоо, ложистикийн	компанийн . . . . .
хэлтсийн захирал албан	албан тушаалтай . . . . .
тушаалтай . . . . .	

/Ц. Дуламсүрэн/

/ . . . . . /

**МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВАГ**

**Хөдөө аж ахуйн биржийн хаяг:**

УБ хот, Сүхбаатар дүүрэг,  
Сүхбаатар дүүрэг, Энхтайвны өргөн  
чөлөө, 18А-1, Монголын хөдөө аж  
ахуйн хоршоологчдын үндэсний холбооны  
байр II давхар

**Холбоо барих утас:**

/976/ 7012-8779

Хөдөө аж ахуйн биржийн цахим шуудан:

info@mce.mn

**Итгэмжлэгдсэн агуулахын хаяг:**

.....

..

**Итгэмжлэгдсэн агуулахын утас:**

/976/ .....

Итгэмжлэгдсэн агуулахын цахим шуудан:

.....

**МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ СУВАГТ ӨӨРЧЛӨЛТ ОРСОН ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ:**

.....  
.....  
.....  
.....  
.....

**ГЭРЭЭНИЙ СУНГАЛТЫГ ҮЙЛДСЭН:**

20 ... оны ... -р сарын ... -ний өдөр

Итгэмжлэлийн гэрээг ... жилийн хугацаатайгаар буюу 20 ... оны ... -р сарын ... -ний өдрийг хүртэл сунгав.

Агуулахын итгэмжлэлийн төлбөр: ..... ₮

Хөдөө аж ахуйн биржийн

Төлбөр тооцоо, ложистикийн

хэлтсийн захирал албан

тушаалтай .....

“ .....”

компанийн .....

албан тушаалтай .....

/Ц. Дуламсүрэн/

/ .....

## **ХАРИЛЦАГЧТАЙ БАЙГУУЛАН МӨРДӨХ ГЭРЭЭНД ЗАЙЛШГҮЙ ТУСГАХ ЖАГСААЛТ**

**Итгэмжлэгдсэн агуулах нь харилцагчтай байгуулах хадгалалтын гэрээнд дараах заалтыг тусгах үүрэг хүлээнэ. Үүнд:**

- Цагийн хуваарь, үйлчилгээний нөхцөл, шимтгэл хураамжийг тохирох;
- Харилцагчийн бараа нь Биржийн барааны тодорхойлолтод илт нийцэхгүй нь тогтоогдвол тухайн барааг хүлээн авахаас татгалзах, тордолт үйлчилгээ явуулахыг санал болгох;
- Биржийн барааг баталгаат жингээр жинлэж хүлээн авах;
- Биржийн бараа хүлээн авсан, хүлээлгэн өгснийг баталгаажуулж, баримт үйлдэх;
- Хадгалалтын явцад биржийн барааны чанар, тоо хэмжээ, хаяглалтын бүрэн бүтэн байдалд өөрчлөлт оруулахгүй байх (жингийн хорогдлыг тооцох);
- Хадгалж буй бараанд болон хадгалалтын нөхцөлд аливаа өөрчлөлт орсон, Биржийн итгэмжлэл түдгэлзэгдсэн, цуцлагдсанаас шалтгаалан харилцагчид үүссэн хохирлыг барагдуулах;
- Харилцагч өөрийн хадгалуулсан барааг буцаан авах тухай хүсэлтийг бичгээр ирүүлсэн даруйд энэ тухай Биржид мэдэгдэх (Харилцагчид буцаан олгох тухай шийдвэрийг Биржээс Итгэмжлэгдсэн агуулахад мэдэгдсэний дагуу шийдвэрлэнэ).

**ИТГЭМЖЛЭГДСЭН АГУУЛАХААС БИРЖИЙН АРИЛЖААНД ОРУУЛАХ,  
АГУУЛАХЫН БҮРТГЭЛИЙН ПРОГРАМД БҮРТГЭХ БОЛОМЖТОЙ  
БАРААНЫ ЖАГСААЛТ**

Барааны нэр	Боловруулалт	Нэмэгдсэн, хасагдсан	Өөрчлөлтийг бүртгэсэн огноо	Биржийн баталгаажуула х гарын үсэг	Итгэмжлэгдсэн агуулахын баталгаажуулах гарын үсэг
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../
				..... /...../	...../ ...../

*Гарын үсэг нь тамга тэмдгээр баталгаажна.*